



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/281

Алтай хот

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 78 дугаар тогтоолоор баталсан "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн 7 дугаар зүйлийн 7.3.1.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 16 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 он үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн үйл ажиллагааг сурталчилах, хэрэгжилтийн үр дүнг сайжруулахад мэргэжлийн зөвлөх болон туслах багийн видео хичээлүүдийг бэлтгэж, архивын сан үүсгэх, хөтөлбөрт хамрагдаж буй багш, сурагч, эцэг эхчүүдэд цахим хичээл, сургалтыг түгээх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрхийг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т олгосугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0200000897